

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АЛТАЙ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

2020.11.07

Есөнбулаг сум
Жаргалант баг

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 29/20 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор А.Мөнх-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудлын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

2019 оны “Говь-Алтай аймгийн Тэргүүний хамт олон”-оор шалгарч өргөмжлөл хүртсэн байна.

Архив, бичиг хэргийн хөтлөлтийн үйл ажиллагаа сайжирч, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Бараа материал, шатахууны тооллогоор зөрчил илрээгүй.

Автомашин болон дизель генераторын хувийн хэргийн хөтлөлт сайн байна.

Дотоод хяналтын баг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд зөвлөл, Галын бүлгэмийн үйл ажиллагаа хангалттай түвшинд явагдаж байна.

Өмнөх дотоод аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалттай түвшинд байна.

Гэрээний бүртгэл хөтлөлтөд анхаарч, гэрээний анхдагч бүрдлийг зааврын дагуу бүрдүүлж ажиллах шаардлагатай байна.

Нягтлан бодох бүртгэлийн програмд бараа материалын бүлгийг буруу сонгосон.

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлж байсан дутагдлаа зассан байгаа хэдий ч мэдээллийг буруу оруулах, мэдээлэхгүй байх, мэдээлэх шаардлагагүй мэдээллийг мэдээлэх зэрэг зөрчил илэрсэн.

Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй байна.

2020 онд шинээр шилжиж ирсэн 2 автомашины шатахуун зарцуулалт болон гүйлтийн нормыг батлуулаагүй.

Тендер шалгаруулалтын журмыг буруу сонгох, хавтаст хэргийг бүрэн бүрдүүлээгүй байх зэрэг зөрчил илэрсэн.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар тус нисэх буудалд 9 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА